



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 онь 05 сарын 21 өдөр

Дугаар 9/294

Хэрлэн сум

**Тусгай зөвшөөрлийн  
хугацаа сунгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:


1.Боловсрол шинжлэх ухааны газрын дүгнэлтийг үндэслэн ерөнхий боловсролын сургуулиудын сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан тул 5 жилийн хугацаатай сунгасугай.

2.Хугацаа сунгах сургуулиудын мэдээллийг хавсралтаар баталсугай.


3.Сургалтын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу чанар, хүртээмжтэй зохион байгуулахыг тус сургуулийн захирлуудад, удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг)-д тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
... дугаар сарын 21 ...-ны өдрийн  
... дугаар захирамжийн хавсралт

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ СУРГУУЛИУД

№	Сум	Сургууль	Тусгай зөвшөөрлийн дугаар	Сунгах хугацаа
1	Хэрлэн	Ерөнхийн боловсролын 1 дүгээр сургууль	№0004539	2023.04.16-2028.04.16
2	Хэрлэн	Хан Хэнтий Ерөнхийн боловсролын сургууль	№0004540	2023.09.19-2028.09.19
3	Хэрлэн	Тэмүүжин Ерөнхийн боловсролын сургууль	№0004541	2023.09.19-2028.09.19
4	Бор-Өндөр	Бор-Өндөр Ерөнхийн боловсролын сургууль	№0004542	2023.09.19-2028.09.19